



**ЗӨВЛӨМЖ**

## **РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД**

2024.06.07

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22 дах хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр радио телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд байнгын хяналт, мониторинг хийж ажиллах бөгөөд хууль, тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10 дах хэсэгт заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлсэн радио, телевиз нь Монгол улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй юм.

/Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх, бүхий радио, телевизийн жагсаалтыг <https://www.crc.gov.mn/pages/show/songuulijn-surtalchilgaa-nevtr-leh-erh-b-hij-radio-televizijn-zhagsaalt> холбоосоор харна уу./

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх **эрхгүй радио, телевиз сурталчилгаа нэвтрүүлсэн бол** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.26-д заасны дагуу тухайн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгох ба Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн арга хэмжээ авах хуулийн зохицуулалттай болохыг онцгой анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс буюу 2024 оны 06 сарын 10-ны өдрөөс эхэлнэ.

Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс /Хоногт нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд оногдох 15 минутаас илүүгүй сонгуулийн сурталчилгаа болон радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр гарах нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх тус бүр 5 минутаас хэтрэхгүй мэдээ/ бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**